



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/456

Улаанбаатар хот


Сургалт зохион байгуулах, сургалтын  
зардал гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9, 8.1.23 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.12 дахь хэсэг, Донорын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.5 дахь заалт, "Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай" Эрүүл мэнд спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 97/56 дугаар хамтарсан тушаал, Эрүүл мэндийн сайдын 2018 оны "Төгсөлтийн дараах сургалтын чиглэл, хяналтын тоо, зардал батлах тухай" А/186 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Донорын тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс эрүүл мэндийн байгууллагын удирдлага, эмнэлгийн мэргэжилтнүүдэд донорын эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны чиглэлээр богино хугацааны сургалт зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.

2. Сургалтад шаардагдах нийт 9,0 сая төгрөгийг энэ онд батлагдсан төгсөлтийн дараах сургалтын зардлын 2018 оны төрөлжсөн мэргэшлийн их эмч, эм зүйчийн сургалтын зардлаас гаргахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дарга /Э.Содномжамц/-д даалгасугай.



081794



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД  
Д.САРАНГЭРЭЛ ТАНАА

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН  
ТӨВ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Энхтайваны гудамж 136, Утас: 7012-8801,  
Факс: (976) 32-06-33, E-mail: admin@hdc.gov.mn,  
<http://www.chd.mohs.mn>

2018.11.01 № 1326  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т


Зөвшөөрөл хүсэх тухай

Донорын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эрүүл мэндийн байгууллагын удирдлага, эмч, мэргэжилтнүүдэд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны талаар сургалт зохион байгуулах шаардлагатай байгаа тул сургалтад шаардагдах 9,0 сая төгрөгийг энэ онд багтаан төгсөлтийн дараах сургалтын зардлаас санхүүжүүлэх зөвшөөрөл олгож өгнө үү.

Тушаалын төсөл (1 хуудас)-ийг хавсаргав.


Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Д.ГАНЦЭЦЭГ

420488

БАТЛАВ:  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  Д.ГАНЦЭЦЭГ

**"ТАРХИНЫ ҮХЭЛТЭЙ ДОНОРООС ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ЭМЧИЛГЭЭ"  
СЭДЭВТ СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ**

№	Зардлын зүйл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зардлын жишиг	Нийт зардал
1	Багшийн ажлын хөлс	хүн/цаг	2/9	20,000	2,880,000
2	Зохион байгуулагчийн ажлын хөлс	хүн/өдөр	1/9	10,000	90,000
3	Туслахын ажлын хөлс	хүн/өдөр	1/9	6,000	54,000
4	Оролцогчдын бичиг хэргийн зардал	хүн	60	2,000	120,000
5	Оролцогчдын цайны зардал	хүн/өдөр	60/9	2,500	1,350,000
6	Оролцогчдын хоолны зардал	хүн/өдөр	60/9	7,000	3,780,000
7	Материал олшруулах	нүүр	2700	50	135,000
8	Хичээлийн агуулга бсловсруулах	хуудас	45	10,000	450,000
9	Сургалтын бусад зардал /хаяг, самбарын үзэг, бичгийн цаас, хавчаар, скоч, утасны зардал гэх мэт бусад /				141,000
	<b>НИЙТ ДҮН</b>				<b>9,000,000</b>

Хянасан: Ахлах нягтлан бодогч



Б.Очир

Боловсруулсан: ЭЭШСҮАЗАлбаны мэргэжилтэн



П.Тунгалаг